

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД АЖЛЫН АЧААЛАЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

Д.Батцогт

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн тэнхимийн дэд профессор, хурандаа

Товч агуулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэж, хүний зөрчигдсөн эрхийг сэргээх, улмаар нийгэмд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн гэм буруутай этгээдийн эрхийг хязгаарлаж байдаг төрийн албадлагын чиг үүргийг гүйцэтгэдэг билээ. Энэхүү хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй уялдан алба хаагч нь бусад төр, хувийн хэвшлийн байгууллагын алба хаагчтай харьцуулахад эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж, аюулгүй байдалд эрсдэл учирч болзошгүй байдаг.

Abstract: The judicial decision-making body executes court decisions on criminal, civil, administrative, and violation cases in accordance with the relevant laws and regulations, performs the state coercive function of restricting the rights of the guilty party aimed at restoring violated human rights and preventing crimes and violations in society. is. In accordance with the duties assigned by this law, civil servants perform duties in risky conditions and may face security risks compared to civil servants of other public and private sector organizations.

Түлхүүр үгс: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих байгууллага, алба хаагч, гэмт хэрэг, аюулгүй байдал.

Key words: Law enforcement, prisons, officers, crime, security.

Оршил

Орчин цагийн шүүхээс гаргасан шийдвэрийг гүйцэтгэх чиг үүрэг бүхий Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага үүсэж хөгжөөд 100 гаран жилийн нүүрийг үзэж байна. Анх зөвхөн хорих ял эдлүүлэх ажиллагааг гүйцэтгэх чиг үүрэгтэй байсан тус байгууллага өнөөдөр эрүү, иргэн, захиргааны шүүхээс гаргасан бүхий л төрлийн шийдвэрийг гүйцэтгэдэг Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болон өргөжин үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

Тус байгууллагын үйл ажиллагааг 1931 он /Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн, ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль/, 1966 он /Засан хүмүүжүүлэх хууль/, 1981 он /Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль/, 1993 он /Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль/, 1996 он /Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль/, 2002 он /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль/, 2017 он /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай/ хуулиудын хүрээнд зохицуулж иржээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрүү, иргэн, захиргааны

хэргийн шүүхээс гаргасан бүхий л төрлийн шийдвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэн, хүний зөрчигдсөн эрхийг сэргээх, улмаар нийгэмд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн гэм буруутай этгээдийн эрхийг хязгаарлаж байдаг төрийн албадлагын чиг үүргийг гүйцэтгэдэг билээ. Энэхүү хуулиар хүлээсэн чиг үүрэгтэйгээ уялдан алба хаагч нь бусад төр, хувийн хэвшлийн байгууллагын алба хаагчтай харьцуулахад ялгаатай талууд ихтэй гэж үздэг.

Сүүлийн жилүүдэд гэмт хэргийн тоо буурахгүйгээр барахгүй шинэ төрлийн гэж тооцож болохуйц улс төр, авлига, албан тушаалын болон хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг өсөх хандлагатай байна.

Энэ нь хорих байгууллагын алба хаагчдын аюулгүй байдалд шууд нөлөөлөхүйц хүчин зүйл гэж үзэж байна.

Хувь хүний аюулгүй байдал гэж амьдрал, эрүүл мэнд, эд хөрөнгийнхөө төлөө өөрийгөө аюул, заналаас халхлах, чөлөөлөх, тэрчлэн иргэн хүний суурь үнэт зүйл болох хуульчилсан эрх, эрх чөлөөг хамгаалах улс, нийгэм, бие хүний чадвар, бэлэн байдал юм.

Эндээс үзэхэд хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдал гэдэг нь албан үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөл, боломжоор хангагдсан байх явдал гэж үзэж болох ба энэ нь зөвхөн гэмт халдлагаар хязгаарлагдахгүй бөгөөд эдийн засаг, улс төрийн нөлөө болон эрх зүйн баталгаагаар хангагдсан байх явдал юм гэж үзлээ.

Үндсэн хэсэг

Хорих байгууллагын алба

хаагчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны тухай ойлголтыг судлахын өмнө аюулгүй байдал, хүний аюулгүй байдал гэж юу болох талаар авч үзэх нь зүйтэй юм.

Судлаач Ч.Улаанхүү “аюул–энэ бол сөрөг үйлчлэлийн бодитой оршин тогтнож байгаа боломж, золгүй байдлыг нүүрлэхийг урьдаас мэдрэх боломж, эсхүл нүүрлэх байдал, аль нэг субъектийн ахуй амьдралд нэн чухал объектууд, байгалийн үнэт зүйлсийг сөнөөх, эсвэл тэдгээрт хор хохирол учруулж унаган төрхийг алдагдуулах, хөгжлийн зам мөрийг хаах боломж бүхий бодитой эсхүл болзошгүй үзэгдэл, үйл явц юм, занал – хэн нэгнийг таагүй байдал, гай зовлонд автагдуулахаар айлган сүрдүүлэх, амлаж андгайлах, илтээр дайсагнагч хүчний зүгээс чиглэл, зорилготой явуулж байгаа аюулын нэн илт, тодорхой, шууд хэлбэр, айдас хүйдэст автуулах замаар аль нэг харилцааны түвшинд давуу байдал олж авах үндсэн зорилготойгоор сөрөг талыг төөрөгдөлд оруулж байгаа арга хэлбэр юм”³³ гэж тодорхойлжээ.

Эрт цагт “аюулгүй байдал” гэдгийг гадны аливаа аюул хөнөөлөөс найдвартай хамгаалагдаж, оюун санааны хувьд тайван байх явдал гэж ойлгодог байжээ. Т.Гобсс, Д.Локк, Ж.Ж.Руссо, Б.Спиноза болон XVII-XVIII зууны үеийн бусад гүн сэтгэгчдийн философийн үзэл баримтлалын үрээр Баруун Европын орнуудад “аюулгүй байдал” хэмээх ойлголт илүү өргөн хүрээнд тархсан бөгөөд аливаа бодит аюул занал арилсан нөхцөлд бүрэлдэн тогтсон амар амгалан байдал /энх тайван/, энэхүү бүрэлдэн тогтоход түлхэц болсон улс төр, эдийн засгийн болон материаллаг

³³ Улаанхүү, Ч. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. УБ., 2014. 69-70 дахь тал.

нөхцөл гэж үзэх болжээ.

Аюулгүй байдлын тухай янз бүрийн олон тодорхойлолт өдгөө томъёологдон гарсан бөгөөд тэдгээр нь тус бүрдээ өөр өөрийнхөөрөө “аюулгүй байдал” хэмээх үзэгдлийн мөн чанарыг тайлбарлах гэж оролддог. Судлаачид хэдийгээр энэ үзэгдлийн бусдаас ялгарах тодорхой, бодит шинж тэмдгийг илрүүлэн тогтоож чадаагүй байгаа боловч, тэр нь бодит /материаллаг/ ертөнц дэх амьд зүйлсийн оршин тогтнох, амьдрах чадварын ямар нэг илэрхийлэл болохыг хүлээн зөвшөөрөөд байгаа билээ. Тиймээс ч аюулгүй байдлын тухай ойлголт нь өнгөц хэлбэрээс шинжлэх ухааны үндэстэй илүү гүнзгий ойлголт руу шилжиж байгаа билээ.

Иргэдийнхээ аюулгүй байдлыг төр хариуцдаг бөгөөд иргэн нь аливаа хүчирхийлэл, халдлага, нэр төрийг нь гутаасан доромжлолд өртөх ёсгүй. Энэ утгаараа Хорих байгууллагын алба хаагчдын аюулгүй байдлыг төр хариуцах учиртай.

Хорих байгууллагын аюулгүй байдлын нэг үндсэн объект нь тэнд ажиллаж буй ажилтан, алба хаагч байна. Аюулгүй байдлыг хангах үүднээс нэг талаас хүний хүний хувийн орон зайн аюулгүй байдал нь нэн тэргүүний бодит хэрэгцээ байдаг.³⁴ Харин нөгөө талаас аюулгүй байдлын нэг үндсэн объект нь хүн байх зүй тогтолтой.³⁵

Хүний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдалтай нягт уялдаатай, түүнийг бэхжүүлэн батжуулж, хүний хөгжлийг сайжруулж, хүний эрхийг дээдлэн өргөжүүлэхэд

оршино. Хүний аюулгүй байдлыг хүний амьдралын бүхий л хэрэгцээ, эрх чөлөөг хангах амин чухал үндсийг хамгаалах явдал гэж тодорхойлж болох юм.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалын 3.4 дэх заалтад “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж төрийн үүргийг тодорхойлон заажээ.

Хорих байгууллагын алба хаагчдын аюулгүй байдлыг хангах ажиллагааг амжилттай зохион байгуулах үндсэн асуудал бол тэдний эрсдэл, хэрэгцээ, шаардлагыг судлах, тогтоох явдал юм. Учир нь төрд тангараг өргөсөн алба хаагч тодорхой хэмжээгээр хязгаарлагдмал эрх эдэлж, онцлог, онцгой хэрэгцээг нь шийдвэрлэх үйл ажиллагаа байна. Тухайлбал, тангараг өргөсөн алба хаагчид нь сонгогдох, нам байгуулах, эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх, жагсаал цуглаан хийх, чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох гэх мэт эрхүүд нь хуулиар³⁶ хязгаарлагдаж байдаг юм.

Иймээс Хорих байгууллагын алба хаагчийн хэрэгцээг авч үзэхдээ иргэний эдлэх бүх эрхийн хандлагад тулгуурлан авч үзэх нь учир дутагдалтай. Онолын хувьд хүний

³⁴ Улаанхүү Ч. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. УБ., 2014. 6 дахь тал.

³⁵ Бор Ж, Чулуунбат В. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс. УБ., 2012. 64 дэх тал.

³⁶ Төрийн албаны тухай хууль. УБ., 2017. 39 дүгээр зүйл.

хэрэгцээг олон янзаар тодорхойлсон байдаг. Үүнд:

- хүн өөрийн бие ба физиологи, оюун санааны хувьд дутагдаж байгаа зүйлээ мэдрэхийг хэрэгцээ гэнэ. Хэдийгээр хэрэгцээ мэдрэгдэж байх ёстой боловч, зарим үед үл мэдрэгдсэн, нуугдмал байдалтай байж болно. Энэ үүднээс авч үзвэл сонирхол, хэрэгцээ хоёр харилцан холбоотой ойлголтууд юм. Ер нь хүнд байнга, тогтвортой ухамсарлагдсан сонирхлыг хэрэгцээ гэж тодорхойлж болох юм.

- хэн нэгэн хүнийг хүндрэл бэрхшээл, зовлонд унагаах нөхцөл байдал, сэтгэл зовоох цаг үе, туйлын хүсэж мөрөөдсөн буюу дутагдаж гачигдсан байдлыг хэрэгцээ гэнэ.

- тухайн өгөгдсөн нөхцөл байдалд нийгмийн тогтолцоо болон хувь хүний аль алинд нь зайлшгүй хэрэгтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай боломжийг хэрэгцээ гэнэ.

Хорих байгууллагын алба хаагч нь нийслэл болон орон нутгийн ямар ч нөхцөлд тодорхой хугацаанд ажиллаж, амьдарч байдаг тул тухайн хувь хүний хэрэгцээг мэдрэх, хэрэгцээг хангах асуудал нь тус байгууллагын удирдлагаас мэргэжлийн ур чадвар шаардсан үйл ажиллагаа юм. Учир нь тухайн байгууллагын алба хаагчид нь өвөрмөц буюу хүнд хэцүү орчинд, төрийн нэрийн өмнөөс хүний зарим эрхийг хязгаарлах үйл ажиллагаа явуулдаг хүмүүс юм. Жишээлбэл, гэмт хэрэгтнийг нийгмээс тусгаарлах, албадлага хэрэглэх гэх мэт.

Алба хаагчдынхаа хэрэгцээг тодорхойлоход дараах үндсэн гурван асуудлыг харгалзан үзэх ёстой. Үүнд:

- Хүний хөгжлийн асуудал /Human development/;

- Хувь хүний ялгаатай

байдал /Human diversity/;

- Нийгмийн тогтолцоо /Social systems/.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль эрх зүйн актуудыг удирдлага болгон өөрийн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад алба хаагчдынхаа аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар иж бүрнээр нь авч үзэхийн тулд дараах цогц ойлголтуудыг товч тодорхойлох шаардлагатай болж байна. Үүнд:

- ШШГБ-ын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлох;

- алба хаагчийн аюулгүй байдалд нөлөөлж буй гадаад болон дотоод хүчин зүйлсийг тогтоох;

- алба хаагчийн аюулгүй байдлын тухай ойлголт түүний тодорхойлолтыг гаргаж ирэх;

- алба хаагчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тогтолцоог бий болгох зэрэг асуудал багтаж байна.

Хорих ял эдэлж байгаа хоригдол, цагдан хоригдож буй хоригдогч нь ямар нэг гэмт санаа бодлоо амжилттай хэрэгжүүлэх, нуун далдлах, өөрийн хань хамсаатантай холбоо тогтоох гэх мэт сөрөг үйлдлийнхээ явцад ажилтан, алба хаагчийн аюулгүй байдалд шууд болон шууд бусаар халдаж болзошгүй байдаг. Тухайлбал, эрхшээлдээ оруулахыг эрмэлзэх, айлган сүрдүүлэх, дарамтлах мөн амь нас, эрүүд мэндэд халдах гэх мэт. Иймээс хорих ангийн ажилтан, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах нь туйлын чухал зорилт юм.

Хэдийгээр ШШГБ-ын офицер, ахлагчид нь алба үүрэг гүйцэтгэх явцдаа дүрэмт хувцас, зарим нөхцөлд зэвсэг, тусгай хэрэгслээр хангагддаг боловч алба хаагчдын аюулгүй байдлыг

хангах арга хэмжээний хүрээнд үүрэг гүйцэтгэхээс бусад цаг хугацаанд, тухайлбал олон нийтийн газарт, ажилд ирэх, буцах замд хэрхэн аюулгүй байдлыг хангах талаар зайлшгүй анхаарч үзэх нь зүйтэй.

Дэлхий нийтэд түгээмэл хэрэглэгдэж буй аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тогтолцоо түүнчлэн хорих ангийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн зарим судалгаа, онолын болон практик дүгнэлтэд тулгуурлан үзвэл хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нь дараах тогтолцоотой байна. Үүнд:

- Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ;
 - Биечилсэн хамгаалалтын арга хэмжээ;
 - Инженер техникийн арга хэмжээ;
 - Нөлөөллийн арга хэмжээ;
 - Гүйцэтгэх ажлын арга хэмжээ
- зэрэг арга хэмжээнүүд багтана.

Аюулгүй байдлыг хангах онолын судалгаанд үндэслэн хорих байгууллагын алба хаагчдын аюулгүй байдлыг дараах байдлаар ангилж, тодорхойлж болохоор байна. Юуны өмнө байгууллагын аюулгүй байдалтай холбон авч үзэх нь зүйтэй юм.

ШШГБ-ын аюулгүй байдлыг хангах гэдэг нь тухайн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулах гадаад, дотоод таатай орчин бүрдсэн байхын зэрэгцээ учирч болох аюул заналыг урьдчилан харах, аюулыг давах чадамжтай байхыг хэлнэ гэж ойлгож болно. Үүнийг дотор нь:

Байгууллагын аюулгүй байдал /объект, байгууламжийн, нууцлалын, мэдээллийн, техник, тоног төхөөрөмжийн гэх зэрэг асуудлууд яригдана/

Хорих байгууллагын алба хаагч нь гэдэгт бүх хорих анги, түүнтэй адил

дэглэм бүхий байгууллага болон цагдан хорих байранд үүрэг гүйцэтгэдэг, хоригдогч, хоригдолтой шууд нүүр тулж ажиллаж буй алба хаагчдыг ойлгож болох бөгөөд эдгээр нь бүх төрлийн аюул заналд өртөж болзошгүй, хамгийн их эрсдэл бүхий хүмүүс юм.

Аюулгүй байдал, аюултай байдал гэсэн хоёр үндсэн асуудал салшгүй холбоотой, харилцан бие биеэ нөхцөлдүүлж байдаг асуудал юм. Иймээс энэ хоёр асуудлыг заавал шинжлэн судалж тийм нөхцөлийг бүрдүүлэх, арилгах гэсэн салшгүй хоёр үйл явцтай холбогдоно.

Түүнчлэн аливаа зүйлийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тодорхойлох гол хүчин зүйлийн нэг нь түүнд нөлөөлж буй гадаад дотоод хүчин зүйлс бөгөөд чухам ямар аюул заналхийлэл нөлөөлж болзошгүй байгааг тогтоох явдал юм. Өөрөөр хэлбэл аюулгүй байдлыг хангах шаардлага, аюул заналхийллийн түвшин, эх сурвалжийг оновчтой тодорхойлох нь зайлшгүй шаардлагатай.

Эндээс тухайн хамгаалагдах шаардлагатай объектын аюулгүй байдал гэдгийг түүний бодит зүй тогтол, хэвийн оршин тогтнох, бусад мөн чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй тэрхүү гадаад дотоод хүчин зүйлс буюу сөрөг нөлөөллөөс хамгаалах нөхцөл хангагдсан байдал буюу аюулгүй байдлыг хангах зорилго амжилттай хэрэгжсэн байдлыг хэлж болох юм.

Хорих байгууллагын алба хаагчдын аюулгүй байдал гэдгийг тухайн алба хаагч нь хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө аливаа аюул заналд өртөхгүй байх нөхцөлийг хэлнэ. Харин алба хаагчдын аюулгүй байдлыг хангах гэдэг нь алба хаагч нь хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө өөрт нь болон гэр

бүлд нь аюул занал учрахгүй байх, хэрэв учирвал түүнийг давах чадамжтай байж, учирсан хохирлыг нөхөн сэргээх механизм бүрдсэн байхыг хэлнэ гэж тодорхойлж байна.

Хорих байгууллага нь хорих ял эдэлж буй хоригдол, цагдан хоригдож буй хоригдогсдын дотроос гэмт хэрэг үйлдэх, нийгэм, иргэдийг гэмт халдлагад өртөхөөс хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага юм³⁷. Хорих ял эдлүүлэх явцад хоригдол дахин гэмт хэрэг үйлдэх, алба хаагчийн аюулгүй байдалд халдах магадлал өндөр байдаг.

Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлийг *Хорих байгууллагын алба хаагчийн ажлын ачаалал* талаас нь авч үзье. Үүнд:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”³⁸-аар нээлттэй, хаалттай хорих ангиудад 20 хоригдол тутамд 1, хаалттай хорих ангийн тусгай нэгжид 5 хоригдол тутамд 1, нийслэл дэх цагдан хорих төвд 10 хоригдогч тутамд 1, орон нутаг дахь цагдан хорих байруудад 20-50 хоригдогчтой бол 2 хамгаалалтын ажилтан биечилсэн хяналт тавихаар тогтоосон.

2017 онд шинэчлэгдэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт “Хорих ангийн алба хаагч биечилсэн хамгаалалт, жижүүрийн үүргийг дөрвөн ээлжээр гүйцэтгэнэ” гэж

заасан, жишиг нормативд 20 хоригдол тутамд 1 харуул хамгаалалтын ажилтан хяналт тавьж ажиллах зохицуулалттай боловч одоогоор алба хаагчдын орон тоог жишиг нормативд зааснаар нэмэгдүүлээгүй зарим хорих анги байгууллагууд харуул хамгаалалтыг гурван ээлжээр зохион байгуулан ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт алба хаагчдын 940 буюу 31,4 хувь нь хоригдол, хоригдогчтой өдөр тутам харьцдаг хамгаалалтын ажилтан /хуучин нэрээр хянагч/ албан тушаалд ажиллаж байгаагаас 556 алба хаагч хоригдолд биечлэн хяналт тавих үүрэг гүйцэтгэдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт “хорих ангийн алба хаагч биечилсэн хамгаалалт, жижүүрийн үүргийг дөрвөн ээлжээр гүйцэтгэнэ” гэж заасан боловч өнөөдрийн байдлаар ихэнх хорих анги 3 ээлжээр харуул хамгаалалтыг зохион байгуулж байгаа нь хорих байгууллагын алба хаагчийн ажлын ачааллыг ихэсгэх нэг үндэслэл болжээ.

Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажилтан 8 цаг буюу 7 хоногт 40 цаг ажиллах заалтын дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч сард 160 цаг, жилд 1920 цаг ажиллах ёстой боловч 24 цагаар жижүүрийн үүрэг гүйцэтгэхээс гадна шуурхай цугларалт, албаны бэлэн байдал, хүчлэн хамгаалалт зэрэг онцлог цаг үеэр илүү цагаар ажилласныг оролцуулахгүйгээр ажлын шаардлагаар

³⁷ Батболд Ч. Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хоригдлын үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл. УБ., 2021. № 01, 02 (26). 189 дэх тал.

³⁸ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаал.

сард 240 цаг, жилд 2880 цаг ажиллаж байна.³⁹

Практикт 1 харуул хамгаалалтын ажилтан 20-оос дээш хоригдолд биечилсэн хяналт тавих тохиолдолд нүдээр үзэж бүрэн хяналт тавих боломжгүй болж, хоригдлууд урьдчилан төлөвлөсөн гэмт санаа бодлоо хэрэгжүүлэх боломж үүсдэг тул 20 хоригдол тутамд 1 харуул хамгаалалтын ажилтан хяналт тавьж ажиллах зохицуулалт бүхий ажлын ачааллын жишиг норматив 2008 оноос мөрдөгдөж байна.

Хорих анги, цагдан хорих байруудад шаардлагатай дүрс бичлэгийн хяналтын ажилтны орон тоог бий болгоход 24 цагийн хугацаагаар үүрэг гүйцэтгэх 200 алба хаагч шаардлагатай бөгөөд дүрс бичлэгийн хяналтын ажилтны орон тоог төсвийн төсөлд тусгадаг боловч төрийн албан хаагчийн орон тоог нэмэгдүүлэхгүй байх чиглэлийн дагуу өнөөг хүртэл шийдвэрлэгдэлгүй, холбооны болон хамгаалалтын ажилтнууд хавсран гүйцэтгэж байна.⁴⁰

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд өнөөдрийн байдлаар хамгаалалтын ажилтан 900 орчим, холбоочин 70 орчим, дүрс бичлэгийн ажилтан 4 орчим ажиллаж байгаа ба “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-аар тооцон үзвэл хамгаалалтын ажилтан **843**, холбоочин **24**, дүрс бичлэгийн хяналтын ажилтан **181**, нийт **1084** алба хаагч ажиллахаар байна.⁴¹

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 232.2 дахь хэсэгт “Хоригдлын биед хийх үзлэг

нэгжлэгийг хоригдолтой ижил хүйсийн алба хаагч гүйцэтгэнэ”, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 33.5 дахь хэсэг “Хоригдсон этгээдийн биед хийх үзлэгийг түүнтэй ижил хийсний хамгаалалтын ажилтан хийх бөгөөд үзлэгээр илэрсэн гэмтэл, шарх сорви болон биеийн жин, өндөр, онцлог, содон тэмдгийг бүртгээж, хувийн хэрэгт нь бүрэн тэмдэглэнэ”, Шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, үзлэг, нэгжлэгийн стандартын 6.1 дэх хэсэгт “...ялтан, хоригдогч бусад этгээдийн бие, хувцас, эд зүйл, тээврийн хэрэгсэл, хорих байр, өрөө, үйлдвэрлэлийн болон бусад зориулалтын барилга, байгууламжид үзлэг, нэгжлэг хийнэ” гэж тус тус заасны дагуу цагдан хоригдож буй эмэгтэй хоригдогч болон хоригдол хоригдогчид эргэлтээр ирж буй иргэдийн бие, эд зүйлд тэдэнтэй ижил хүйсийн алба хаагчаар үзлэг хийлгэх шаардлага тулгардаг ба практикт эмэгтэй хамгаалалтын ажилтан байхгүйгээс санхүү, эмнэлгийн албаны эмэгтэй алба хаагчдаар үзлэг хийлгэдэг ба тэдгээр нь үзлэг нэгжлэгийг дутуу хийх, нүд дассан байдлаар ажилласнаар хорих анги, цагдан хорих байранд хориотой эд зүйд нэвтрүүлэх боломж олгож байгаа нь хорих байгууллагын алба хаагчдын аюулгүй байдалд шууд нөлөөлөх хүчин зүйл болж байна.

ДҮГНЭЛТ

Төрийн албаны болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд алба хаагчийн хувьд төрийн албан хаагчийн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн, хорих байгууллагын алба

³⁹ Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл 181 дэх тал.

⁴⁰ ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны судалгааны тайлан. 2018.

⁴¹ ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны судалгааны тайлан. 2019

хаагчийнхаа хувьд эдлэх эрх зүйн баталгааг хуульчилж өгсөн боловч ажлын ачааллаас шалтгаалан эрхээ эдэлж чадахгүй байна гэж дүгнэлээ.

Хорих байгууллагын алба хаагчдын аюулгүй байдал гэдгийг тухайн алба хаагч нь хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө аливаа аюул заналд өртөхгүй байх нөхцөлийг хэлэх ба тэдний аюулгүй байдлыг хангах гэдэг нь алба хаагч нь хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө өөрт нь болон гэр бүлд нь аюул занал учрахгүй байх, хэрэв учирвал түүнийг давах чадамжтай байж, учирсан хохирлыг нөхөн сэргээх механизм бүрдсэн байхыг хэлнэ гэж тодорхойлж байна.

Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл нь зөвхөн хоригдол, хоригдогчийн зүгээс үйлдэж болзошгүй гэмт халдлагаар хязгаарлагдахгүй бөгөөд нийгмийн хэрэгцээ, шаардлагаас хамааран хөдөлмөрийн аюулгүй байдал, гэр бүлийн аюулгүй байдал, улс төр, эдийн засгийн аюулгүй байдал зэрэг олон төрөлтэй байна.

Алба хаагчийн аюулгүй байдлыг хангах нэг чухал арга хэмжээ бол төрийн тогтвортой, баталгаатай ажил, албан тушаал бөгөөд шатлан дэвших зарчимд нийцсэн хүний нөөцийн зөв тогтолцоог бий болгох нь зүйтэй юм.

Түүнчлэн хоригдол, хоригдогчийн зүгээс алба хаагчдын эрхшээлдээ оруулах, хувийн харьцаа тогтоох оролдлого тасралтгүй хийсээр байгаад онцгой анхаарах шаардлагатай байна.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын зүгээс хорих

байгууллагын алба хаагчдын аюулгүй байдлыг хангахтай холбоотой бүтэц, удирдлага, зохион байгуулалт бий болгон ажиллах хэрэгцээ судалгааны явцад ажиглагдлаа.

САНАЛ

Судалгааны явцад гаргасан дүгнэлтдээ үндэслэн Хорих байгууллагын алба хаагчийн эрх зүйн зохицуулалт, удирдлага зохион байгуулалт боловсронгуй болгох чиглэлээрх дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны хөгжлийн бодлогын барим бичиг”-г алба хаагчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохицуулалт оруулах;

2. Хорих ангийн бүтэц зохион байгуулалтад алба хаагчийн аюулгүй байдлыг хангах мэргэшсэн ажилтан бэлтгэж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах;

3. Алба хаагч-хоригдлын харьцааны стандартыг бий болгон үйл ажиллагаанд нэвтрүүлэх зэрэг болно.

4. Техник, технологи өндөр хөгжсөн гадаад улсын практик туршлагыг судлан үзэхэд ХБНГУ, БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонг-Конгийн хорих байгууллагад теле хяналтын систем өргөн нэвтэрсэн хэдий ч хүний хүчин зүйл, биечилсэн хяналтыг орхигдуулалгүй 1 харуул хамгаалалтын ажилтан 6-8 хоригдолд биечилсэн хяналт тавин ажилладаг байна үүнтэй адил тогтолцоонд шилжих зэрэг саналыг дэвшүүлж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль, тогтоомж

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он.

5. Хорих ангийн дотоод журам. 2017 он.

6. Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн тойрог тогтоох журам. 2017 он.

Хоёр. Ном сурах бичиг, гарын авлага

1. Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдал. Уб. 2017.

2. Алтангэрэл Б. Хорих ял эдлүүлэх ажиллагаа. Уб., 2018.

3. Улаанхүү Ч. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. Уб., 2014.

4. Лхагва А. Гяндан салаанаас Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий

газар болж өргөжсөн түүхэн замнал. Уб., 2001.

5. ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэн. ШШГБ-ын хүний нөөцийн эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. Уб., 2019.

Гурав. Бусад эх сурвалж

1. ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны судалгааны тайлан. 2018 он.

2. ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны судалгааны тайлан. 2019 он.

3. ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны тайлан. 2022 он.

4. Батболд Ч. Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хоригдлын үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл. Уб., 2021. № 01, 02 (26).

Дөрөв. Цахим эх сурвалж

www.legalinfo.mn
www.cd.gov.mn